

САНХҮҮГИЙН ДЭМЖЛЭГТ ХАМРАГДСАН ИРГЭДИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХЯНАЛТ

2022 оны 8 угаар сарын 16-ны өдрийн газрын даргын баталсан удирдамжийн дагуу Дэрэн, Өндөршил сумдад дараах ажлыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:

Хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэд санхүүгийн дэмжлэгт хамрагдаж ажлын байр бий болгосон эсэх, үйл ажиллагааг тогтвортой явуулсан эсэх, ажил олоход хүндрэлтэй иргэдийг ажлын байраар хангаж орлого нэмэгдсэн эсэхэд хяналт тавьж, аливаа эрсдэлээс хамгаалах, зээлийн хугацаа хэтрэлт гаргахгүй байх талаар арга зүйн зөвлөгөө өгч ажиллалаа.

Дэрэн сум Ахмадын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн санхүүгийн дэмжлэгт хамрагдсан С.Эрдэнэбилэг- Арьс шир боловсруулах төсөл. Үйл ажиллагаагаа явуулаад эхэлсэн ч санхүүжилтийн зарцуулалт тодорхойгүй 1 сая төгрөгөөр арьс худалдан авч 4 сая төгрөгөөр ажлын байраа засварласан нь санхүүжилтийн зарцуулалт төслийн дагуу зарцуулагдаагүй. Төсөлд арьс элдэгч машин авна гэж тусгасан ч аваагүй, орлого зарлагын тооцоолол хийгээгүй зэрэг алдаа зөрчлүүд гарсныг ахлах мэргэжилтэн Т.Лхагвасүрэн мэдээлэл арга зүйгээр ханган заавар зөвлөгөө өгч гарсан зөрчлийг арилгах, төсөлд тусгагдсан машинаа худалдан авч нотлох баримтын хамт сум хариуцсан мэргэжилтэнд хүлээлгэн өгөх, орлого зарлагын дэвтрийн хөтөлгөөг тогтмол хийж байх талаар анхааруулсан. Зээлийн эргэн төлөлт хуваарийн дагуу хугацаанд нь хийгдсэн санхүүжилт авснаас хойш 1,2 сая төгрөгийн борлуулалтын орлоготой ажилласан байна.



Дэрэн сум: Аж ахуй эрхлэгчдийг дэмжих хөтөлбөрийн санхүүгийн дэмжлэгт хамрагдсан А.Олзбаярын Миний урлан төсөл. Төсөл хэрэгжүүлэгч нь хөдөө явсан учир хяналт хийх боломжгүй болсон.

Өндөршил сум: Аж ахуй эрхлэгчдийг дэмжих хөтөлбөрийн санхүүгийн дэмжлэгт хамрагдсан М.Шинэбаярын Дэгжин гутал төсөл. Үйл ажиллагаа явуулж байгаа эсэх нь тодорхойгүй, 5 сая төгрөгийн санхүүжилтээр тоног төхөөрөмж захиалсан одоо болтол ирээгүй, үлдэгдэл 5 сая төгрөг дансандаа байгаа ч нотлох боломжгүй, зээлийн эргэн төлөлт хуваарийн дагуу хийгдсэн, санхүүжилт авснаас хойш 287,000 төгрөгийн борлуулалтын орлоготой ажилласан. Төслийн зарцуулалтыг бүрэн зарцуулаагүй тул үнэлэх боломжгүй. Сар бүр орлого зарлагын хөтөлгөө хийж хэвших, санхүүжилтийн зарцуулалтыг нотлох баримтын хамт сум хариуцсан мэргэжилтэнд өгөх, нийгмийн даатгалын шимтгэл сайн дураар төлөх талаар заавар зөвлөгөө өгч ажилласан.

